



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/827.

Мандалговь

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс  
урьдчилан сэргийлэх арга хэмжээнд  
зардал гаргах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэдалай сумын багуудад малын гоц халдварт шүлхий өвчинголомтлон гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 14,950.000 (Арван дөрвөн сая есөн зуун тавин мянган) төгрөг гаргасугай.
2. Зардлын тооцооллыг хавсралтаар баталсугай.
3. Зардалд шаардагдах 14,950.000 (Арван дөрвөн сая есөн зуун тавин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210937